



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Тайланг хянасан:

Төсвийн Ерөнхийлөн захирагч

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ...../ У.БОЛДХҮҮ/

(албан тушаал)

(гарын үсэг)

Тэмдэг

.....
(огноо)

Тайлан гаргасан:

Төсвийн Шууд захирагч

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА...../Г.ЧҮЛТЭМЖАМЦ/

(албан тушаал)

(гарын үсэг)

Тэмдэг

.....
(огноо)

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
<p align="center">ЗОРИЛГО 1.БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ /Алсын хараа-2050 зорилт 5.3 дахь заалт,Улсын бүртгэлийн байгууллагын 2021-2024 оны стратегийн зорилт, УБЕГ-ын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө /</p>						
<p align="center">Зорилт 1. Инновацийг дэмжигч, итгэл хүлээсэн, ил тод, нээлттэй төрийн үйлчилгээний байгууллага байна.</p>						
1.1	Иргэдэд тоон гарын үсэг олгох ажлыг эрчимжүүлэх	Хүсэлт гаргасан иргэдэд олгосон тоон гарын үсгийн хувь: -	60,5	80	Тоон гарын үсэг олгох ажлын хүрээнд 3 удаа арга хэмжээ зохион байгуулж, 2024 оны 11 дүгээр сарын 18-ны байдлаар нийт 30,782 иргэнд тоон гарын үсэг олгож 82,0 %-тай байна	
1.2	Улсын бүртгэлийн Зөрчлөөс урьдчилан сэргийлэх, улсын бүртгэлийн хууль тогтоомжийг сурталчлах, соён гэгээрүүлэх чиглэлээр контент бэлтгэж түгээх	Сурталчилсан хэвлэл, мэдээллийн хэрэгслийн төрөл: Сурталчилсан мэдээ мэдээлэл, сурталчилгаа контентын тоо:	-	3	Улсын бүртгэлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, улсын бүртгэлийн хууль тогтоомжийг сурталчлах, соён гэгээрүүлэх чиглэлээр 4 контент бэлтгэж иргэн, хуулийн этгээдэд сурталчиллаа. Үүнд: 1.Иргэний үнэмлэхний 25,45 насны сунгалт 2.Шилжилт хөдөлгөөний бүртгэл 3.Үл хөдлөх хөрөнгийн хаягийн өөрчлөх 4. Өмчилсөн газрын хаяг өөрчлөх	
			-	3		

1.3	Улсын бүртгэлийн үйлчилгээг цахим машинаар /Киоск/ үзүүлэх	Улсын бүртгэлийн үйлчилгээг цахим машинаар /Киоск/ үзүүлсэн үйлчилгээний тоо ;	150	450	2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар Киоск машинаар лавлагаа- 4119 , тоон гарын үсэг олгох- 5210 үйлчилгээг тус тус үзүүлж пос машинаар төлбөр төлөх үйлчилгээг 306 иргэн авсан байна.
1.4	Улсын бүртгэлийн үйлчилгээнд өгөгдлийн шинжилгээ хийх	Бүртгэлийн үйлчилгээнд дүн шинжилгээ хийсэн тоо;	-	4	Улсын бүртгэлийн үйлчилгээнд өгөгдлийн шинжилгээг 4 удаа хийсэн.
Зорилт 2. Цахим бүртгэлийг хөгжүүлэх замаар улсын бүртгэлийн үйлчилгээний чанар, хүртээмж, шуурхай байдлыг нэмэгдүүлнэ.					
2.1	“Улсын бүртгэлийн үйлчилгээний төв болон цэг”-ийн үзүүлж байгаа үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх	Улсын бүртгэлийн зөөврийн тоног төхөөрөмжөөр үзүүлсэн үйлчилгээний тоо;	180	300	Улсын бүртгэлийн зөөврийн тоног төхөөрөмжөөр 121 иргэнд үйлчилгээг үзүүллээ. 2024.01.31-ны өдрөөс тус хэлтэс Киоск машинаар 24 цагаар иргэдэд үйлчлэх 24/7 үйлчилгээг нэвтрүүлэн ажиллаж байна.
		Нэмэгдсэн 24/7 цэгийн тоо;	-	1	
2.2	Улсын бүртгэлийг хууль тогтоомж, холбогдох журмын дагуу эрхлэн хөтлөх	Иргэний улсын бүртгэл хөтөлсөн хувь ;	100	100	Тайлант хугацаанд иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 10326 , хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 2001 , эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 4401 бүртгэлийг улсын бүртгэлийн хууль тогтоомж, холбогдох журмын дагуу бүртгэсэн байна.
		Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтөлсөн хувь;	100	100	
		Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтөлсөн хувь;	100	100	
2.3	Е-mongolia төрийн үйлчилгээний системээр улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлэх	Е-Mongolia цахим системээр улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн бүртгэлийн тоо;	5	100	2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар Е-mongolia төрийн үйлчилгээний системд 52 иргэн шилжилт хөдөлгөөний бүртгэл хийлгэх хүсэлт илгээснээс нотлох баримтын бүрдүүлэлт хангасан 20 иргэний бүртгэлийг бүртгэж баталгаажуулсан. Бусад 32 иргэний бүрдүүлсэн материал нотлох

					баримтын шаардлага хангаагүй тул бүртгэх боломжгүйг мэдэгдэж татгалзсан.
2.4	Алслагдсан сумаас эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх	-Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлж буй сумдын тоо;	5	11	Аймгийн төвөөс алслагдсан Алтай, Чандмань, Тонхил, Баян-Уул, Халиун, Цогт, Цээл, Бигэр, Эрдэнэ, Дэлгэр, Хөхморьт сумдын улсын бүртгэгчид эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлж 2024 оны 11 сарын 20-ны байдлаар 405 бүртгэл хөтөлсөн байна.
		-Сумын улсын бүртгэгчийн хөтөлсөн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тоо;	219	400	
2.5	Барьцааны гэрээний болон барьцааны гэрээ дуусгавар болгох бүртгэлийг цахимаар бүртгэх	- Цахимаар бүртгэсэн барьцааны гэрээний бүртгэлийн тоо;	-	30	Барьцааны гэрээний болон барьцааны гэрээ дуусгавар болгох, бүртгэлийг цахимаар бүртгэх систем хэрэглээнд нэвтрүүлэх бэлтгэл ажлыг бүрэн хангаж мэдээллийн сан дахь алдаатай 126 бүртгэлийн 126 мэдээллийг засаж засвар, өөрчлөлт оруулан зөрчлийг арилгалаа. Барьцаа дуусгавар болгох 34 бүртгэлийг цахимаар хүлээн авч бүртгэлээ.
		- Цахимаар бүртгэсэн барьцааны гэрээ дуусгавар болгох бүртгэлийн тоо;	-	30	
2.6	Аймгийн төвөөс алслагдсан зарим сумдын улсын бүртгэгч нарт гадаад паспортын эрх нээх	Гадаад паспортын эрх нээсэн тоо;	1	2	Бугат суманд Улсын бүртгэгч Б.Рэнцэндорж 2024.01.05-ны өдрөөс гадаад паспортын бүртгэлийн үйлчилгээг үзүүлж байна.2024 онд 94 иргэнд гадаад паспорт олгожээ.
		Гадаад паспорт олгосон тоо;	3	20	
2.7	Улсын бүртгэлийн “Нээлттэй өдөр” арга хэмжээг зохион байгуулах	“Нээлттэй өдөр” арга хэмжээг зохион байгуулсан тоо;	5	10	Улсын бүртгэлийн “Нээлттэй өдөр” арга хэмжээг дараахь 5 удаа зохион байгуулсан. Үүнд: - 2024.02.05-ны өдөр Аймгийн Засаг даргын тамгын газартай - 2024.05.01-ны өдөр Аймгийн Засаг даргын тамгын газар, Хуулийн

					<p>хүрээний тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудтай хамтран “ПРО БОНО” өдөрлөг</p> <p>- 2024.05.17-ны өдөр Аймгийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 589 тоот “Байгууллага сурталчлах аян”-ны хүрээнд Нээлттэй өдөрлөг</p> <p>-2024.09.20-ны өдөр Аймгийн Засаг Даргын Тамгын Газар, ХХҮГ, ГБХЗХГазруудтай хамтран “ХҮРЧ ҮЙЛЧИЛНЭ” аяны хүрээнд “Нээлттэй өдөрлөг”</p> <p>-2024.10.02-ны өдөр Аймгийн Нийгмийн Даатгалын газар, ХХҮГазартай хамтран Шинэ-Алтай захын гадна талбайд “АХМАДАА ХАЙРЛАЯ, ХҮНДЭТГЭЕ” сэдэвт “Нээлттэй өдөрлөг”-ийг тус тус зохион байгууллаа. Дээрхи зохион байгуулсан “Нээлттэй өдөрлөг”үүдийн үеэр нийт 72 иргэн, 28 хуулийн этгээдэд улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлж 643 иргэнд тоон гарын үсэг олгон 9 ахмад настанд гарын бэлэг олголоо.</p>	
Зорилт 3.Улсын бүртгэлийн мэдээллийн аюулгүй байдал, нэгдсэн сангийн нууцлалыг ханган, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ.						
3.1	Улсын бүртгэлийн цахим мэдээллийн нэгдсэн сан, мэдээллийн нэгдсэн сүлжээ, мэдээллийн системийн хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хариуцах, техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах	Тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаанаас шалтгаалсан доголдлыг арилгасан хувь ;	100	100	2024 онд хэлтсийн хэмжээнд ашиглагдаж буй техник, тоног төхөөрөмжид 6 удаа засвар үйлчилгээ, тохиргоог хийсэн. Хэлтсийн серверийн рөүтерийг МТГ-аас Sophos router-ээр шинэчлэсэн бөгөөд тохиргоог заасан хугацаанд нь хийлгүүлэн ашиглаж байна.Хэлтсийн төв серверийг хэлтсийн 2 давхарт нүүлгэн	

					шилжүүлсэн. Аймгийн төвийн дотоод сүлжээ дамжуулагч Media Converter шатсаныг шинэчилж Бугат, Бигэр, Хөхморьт, Шарга, Баян-Уул, Алтай, Цээл, Дарив, Тонхил сумдын сүлжээний доголдлыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын инженертэй холбогдон рөүтерийн лангийн порт сольж тохиргоо хийлгэн хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж байна.	
3.2	Улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаанд хяналт тавих.	Хяналт шалгалт хийсэн тоо;	12	15	2024 онд Хяналт шалгалтын ажлын 9 заалт бүхий төлөвлөгөөг гаргаж, хэлтсийн даргаар батлуулан төлөвлөгөөний дагуу иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээд, архивын лавлагаа олгосон бүртгэлд өдөр тутмын хяналт тавьж хэрэгжилтийг ханган ажиллалаа. Төлөвлөгөөт шалгалт 6, төлөвлөгөөт бус шалгалт 2, өргөдөл, санал, гомдлын мөрөөр 26 удаагийн шалгалт хийсэн байна.	
3.3	Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх хуульд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх	Шалган шийдвэрлэсэн зөрчлийн хувь;	100	100	2024 оны 11 сарын 20-ны байдлаар Зөрчлийн тухай болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хүрээнд 130 хүн, 3 хуулийн этгээдийн гомдол мэдээллийг хүлээн авч, Прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэн, хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг явуулж, улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрчсөн 130 хүн, 3 хуулийн этгээдэд нийт 4.190.000 төгрөгийн торгох шийтгэл ноогдуулж ажиллав.	
3.4	Архивын байрны хадгалалт, хамгаалалт, хадгаламжийн сангийн нөхцөл байдлыг сайжруулж байгууллагын	Архивын хадгалалт, хамгаалалтыг сайжруулахад хэрэгжүүлсэн ажлын тоо;	6	10	2024 оны 3 сард эд хөрөнгийн бүртгэлийн болон байгууллагын архивыг тусгаарлан тус тусад нь 2 өрөөнд байршууллаа.	

	архивыг бүртгэлийн архиваас тусгаарлах					
3.5	Төсвийн хөрөнгийг зүй зохистой, хэмнэлттэй зарцуулах, тайлагнах, байршуулах	Тайлагнасан мэдээллийн мөнгөн дүн;	1,183,313,471.00 төг	1,101,091,400.00 төг	2024 оны 11-р сарын 15-ны өдрийн байдлаар 1,478,245,500.00 төгрөгийн урсгал үйл ажиллагааны санхүүжилт авч, 1,284,317,712.92 төгрөгийг зориулалтын дагуу төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулж ажилласан. 2024 онд 95.0 сая төгрөг улсын төсөвт төвлөрүүлэхээс 10 сарын 31-ны өдрийн байдлаар бүртгэлийн үйлчилгээний орлого 103.7 сая төгрөгийг төвлөрүүлж биелэлт 109% -тай байна. Санхүүгийн үйл ажиллагаанд Аймгийн Төрийн аудитын газраас аудит хийж “ӨӨРЧЛӨЛТГҮЙ” дүгнэлт өгсөн. Акт, албан шаардлага, зөвлөмж аваагүй болно 2024.10.31-ны өдрийн байдлаар Шилэн дансны тухай хуулийн дагуу https://info.shilendans.gov.mn/ цахим хуудсанд 139 мэдээллийг хугацаанд нь байршуулсан бөгөөд хугацаа хоцорсон, огт оруулаагүй мэдээлэл байхгүй.	159
		Хугацаандаа байршуулсан шилэн дансны мэдээллийн тоо;				
Зорилт 4. Хуулиар олгосон тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх						
4.1	Монгол Улсын Их хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар УБЕГ-аас гаргасан нарийвчилсан төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах	Нарийвчилсан төлөвлөгөөний биелэлтийн хувь;	-	100	МУИХ-ын сонгуулийн тухай хуулинд заасан Улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэх чиг үүргийн дагуу УБЕГ-ын сонгуулиар хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжилтийг 100 хувь хэрэгжүүлэн ажилласан.	

4.2	Аймаг, сумын ИТХ-ын ээлжит сонгуулиар Улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэхээр заасан чиг үүргийг ханган ажиллах	Улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийн хувь;	-	100	Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын ээлжит сонгуулиар Улсын бүртгэлийн байгууллагын хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэн ямар нэгэн алдаа, зөрчилгүй ажилласан.
Зорилт 5. Төсөл хөтөлбөр хэрэгжүүлнэ. /Аймгийн удирдлага болон орон нутгийн төрийн бусад байгууллагатай хамтарч ажиллах/					
5.1	Аймгийн ИТХ, Засаг дарга болон төрийн байгууллагуудтай хамтран ажиллаж дэмжлэг авах	Санал, хүсэлт тавьж шийдвэрлүүлсэн ажлын тоо;	1	1	2024 оны 11-р сарын 15-ны өдрийн байдлаар Аймгийн ЗДТГазраас төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдад орон нутгийн нэмэгдэлд 26,744,000.00 төгрөгийн нэмэлт санхүүжилт авч нийт 33 албан хаагчид орон нутгийн нэмэгдлийг сар бүр 10 хувиар тооцон олгож байна.
Зорилт 6. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр хэрэгжүүлнэ.					
6.1	Улсын бүртгэлийн ерөнхий газрын авлигын эрсдлийг бууруулах хамтарсан хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллах	Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлын тоо;	-	1	Улсын бүртгэлийн ерөнхий газрын авлигын эрсдлийг бууруулах хамтарсан хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хөтөлбөрийн хүрээнд 2024.01 сард Аймгийн ЗДТГ, АТГ-ын хамтран зохион байгуулсан цахим сургалтанд төрийн захиргааны 14 албан хаагч хамрагдлаа. 2024.09.13-ны өдөр Аймгийн Нийгмийн Даатгалын газартай хамтран “Авлигыг үл тэвчье” сэдвээр “НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГ” -ийг Шинэ-Алтай захын гадна задгай талбайд зохион байгууллаа. Энэ үеэр авлигыг үл тэвчих агуулга бүхий брошур, гарын авлагыг 187 иргэнд танилцуулж сурталчиллаа..

6.2	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах	АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ, мэдээллийн самбарт байршуулж, олон нийтэд хүргэсэн тоо;	-	5	АТГ-аас бэлтгэсэн 3 тв шторк , 1 инфографик, 2 гарын авлагыг Улсын бүртгэлийн хэлтсийн цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулж, олон нийтэд хүргэж байна.	
Зорилт 7. Чадахуйн зарчимд суурилсан хүний нөөцийг бүрдүүлж, албан хаагчдын нийгмийн баталгааг хангана.						
7.1	Улсын бүртгэлийн ерөнхий газраас батлагдсан “Албан хаагчийн сургалтын хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь;	90	100	Албан хаагчдыг дараахь сургалтуудад хамрууллаа.Үүнд: -МУИХ-ын сонгуулийн тухай хуулийн сургалт /2024.01.26/ -Суманд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх эрх олгогдсон 6 улсын бүртгэгчийг чадавхжуулах танхимын сургалт(2024.05,20-06.01) -Хуулийн этгээдийн улсын бүртгэлийг суманд хөтлөх эрх олгогдсон 11 улсын бүртгэгчийг чадавхжуулах танхимын сургалт (2024.05.30,31) - УБЕГ-аас Дорнод аймагт зохион байгуулсан сумдын улсын бүртгэгчдийг чадавхжуулах сургалтанд 24 албан хаагч (2024.08.14,15) -УБЕГ, Койка олон улсын байгууллага хамтран Солонгос улсад зохион байгуулсан 10 хоногийн сургалтанд 1 албан хаагч (2024.09 сард) тус тус хамрагдлаа.	

7.2	“Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа хангах дунд хугацааны хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг ханган ажиллах	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь;	90	100	- Аймгийн ЭМГазартай хамтран эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт 2024.05.11-ны өдөр 15 албан хаагч, 2024.10.03-ны өдөр сумдын 12 улсын бүртгэгчийг хамрууллаа. -Албан хаагчдын ажиллах ая тухтай нөхцөл, иргэдийн үйлчилгээ авах таатай орчныг бүрдүүлэн хэлтсийн үйлчилгээний заалыг өргөтгөх ажлыг 2024.03 сард хийж ашиглалтанд орууллаа. - Хэлтсийн байрны 2 давхарт дартс, теннисний өрөөг тус тус тохижуулан ашиглаж байна. Аймгийн БТСГазартай гэрээ байгуулан албан хаагчдыг долоо хоног бүрийн 4 дэх өдөр волейбол, сагсан бөмбөгийн спортоор хичээлүүлж 2024 онд спортын арга хэмжээг 3 удаа зохион байгуулав.
7.3	Улсын бүртгэлийн байгууллагын хүний нөөц, сургалтын нэгдсэн системээр зохион байгуулагдсан сургалтанд албан хаагчдыг бүрэн хамруулах	Сургалтад хамрагдаж шалгалт өгсөн албан хаагчийн тоо;	32	34	Улсын бүртгэлийн байгууллагын хүний нөөц, сургалтын нэгдсэн системд байршуулсан Бие даах хичээлийг Төрийн захиргааны 28 , төрийн үйлчилгээний 4 албан хаагч нийт 135 хичээл үзэхээс ТЗ-ны албан хаагчид 82 хичээл, төрийн үйлчилгээний албан хаагчид 5 хичээл судалсан байна
7.4	Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, хяналт тавих	-Ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувь;	100	100	Тайлант хугацаанд тус хэлтсээс нийт 433 албан тоотыг явуулснаас Хууль хяналтын байгууллагад 80 , Аймгийн ЗДТГ, ИТХ-д 87 , УБЕГ-т 208 , бусад албан байгууллага аймаг руу 58 албан бичгийг тус тус хүргүүллээ. 691 албан бичиг ирсэн. Үүнд: Хууль хяналтын байгууллагаас 175 , Аймгийн ЗДТГ, ИТХ-аас- 78 , УБЕГ-аас 340 , бусад байгууллагаас 118 бичиг ирсэн байна.

					<p>Тайлант хугацаанд хэлтэст нийт 400 хариутай бичиг ирсэн.Үүнд: Хууль, хяналтын байгууллагаас 113, аймгийн ЗДТГ, ИТХ-аас 53, УБЕГ-аас 162, бусад байгууллагаас 72 албан бичиг ирсэнийг 100 хувь шийдвэрлэсэн.</p> <p>Хэлтэст 61 өргөдөл ирснээс 58 өргөдлийг хуулийн хугацаанд нь бүрэн шийдвэрлэж 3 өргөдөл шийдвэрлэх шатандаа байна.</p>	
--	--	--	--	--	-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	--

--oOo--